



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 09 дүгээр сарын 16

№



Улаангом сум

1. Тендерийн нэр: “Улаангомyn дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн К3 зуухны иж бүрэн уут солих
2. Барааны нэр: Уутан фильтерийн уут, Уутан фильтерийн компрессор

№		
1.	Үндэслэл	Байгаль орчин, аялал жуулчалын сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Агаар орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлыг шинэчлэн батлах тухай” А/423 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын 16 дахь хэсэг;
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Увс аймгийн Улаангом сум, “Улаангомyn дулааны хоёрдугаар станц” ТӨХК-ийн К3 зуух;
3.	Зориулалт, хүчин чадал	Уутан фильтерийн уут хуучирч цоорсон уут солих;
4.	Одоогийн байдал	Уутан фильтерийн уутнууд цоорч утааны хийнээс үнс тортог бүрэн шүүж чадахгүй байгаа, уутан фильтерийн үндсэн тоноглол болох компрессор хуучирч гэмтэл их гарч байгаа солих шаардлагатай болсон;
5.	Захиалагч	Увс аймгийн Засаг дарга

6.	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, нийлүүлэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;
7.	Төсөл гүйцэтгэх байгууллага:	Бараа нийлүүлэх хуулийн этгээд;
8.	Шаардагдах хөрөнгийн хэмжээ:	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр баталсан "Агаар орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлаар санхүүжигдэх 259,200,000 (хоёр зуун тавин есөн сая хоёр зуун мянга) төгрөг;
9.	Ажлын үе шат:	Техникийн тодорхойлолтын дагуу бараа татан авч ирж хүлээлгэн өгөх
10.	Иж бүрдэл:	Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтад заасан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу бичиг баримтыг 4 хувь үйлдэж бүрдүүлж өгнө;
11.	Нэмэлт нөхцөл:	<ul style="list-style-type: none"> - Бараа нийлүүлэх компани нь бараа бүтээгдэхүүнийг захиалагчид гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх; - Нийлүүлэх тоног төхөөрөмж нь ППС96-3 маркийн уутат филтерт тохирох, техникийн тодорхойлолтыг бүрэн хангасан, шинэ байх; - Барааг хүлээлгэн өгөх эцсийн цэг- Увс аймгийн Улаангом сум

НИЙЛҮҮЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Барааны нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1.	Уутан фильтерийн уут	4000*133 мм	ш	840	
2.	Уутан компрессор фильтерийн	22 кВт	ш	2	

3. Уутан фильтерийн уутны техникийн үзүүлэлт

1. Хэмжээ: 4000*133 мм
2. Ажлын температур: +100⁰C - +200⁰C
3. Эдэлгээ: 5760 цагаас багагүй
4. Материал: Aramid fiber, PTFE, glass fiber chopped
5. Гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай.

4. Уутан фильтерийн компрессорын техникийн үзүүлэлт

1. Хөдөлгүүрийн хүчин чадал: 22 кВт-аас багагүй
2. Бүтээмж: 5,5 м3-аас багагүй
3. Компрессорын төрөл: Шурган /Screw/
4. Ажиллах хүчдэл: 380 вольт
5. Компрессорын марк төрөл: SLD буюу түүнтэй дүйцэхүйц
6. Гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай.
7. Нэмэлт: Эхний 2 удаа солих маслын шүүр, агаар шүүгч, компресорын тос дагалдуулж өгөх

Захиалагчийн хяналт: Увс аймгийн засаг дарга, Улаангомын дулааны хоёрдугаар станц ТӨХК

- Бараа материалын чанар, тоо хэмжээ, стандарт маркийн дагуу хугацаандаа нийлүүлэгдэж байгаа эсэх.
- Бараа материал нь чанартай, улсын үйлдвэрийнх байх.
- Бараа, материал нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно.

Нийлүүлэгч байгууллага:

- Нийлүүлэгч хуулийн этгээд нь уутан фильтр угсрах суурилуулах, уутан фильтр нийлүүлж байсан ажлын туршлагатай байх.
- Нийлүүлэгч байгууллага нь тоо хэмжээний дагуу чанартай бараа материалыг гэрээний хугацаанд багтаан нийлүүлэх.
- Тендерт шалгарсан нийлүүлэгч нь импортын бараа материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторын шинжилгээний дүнг хавсаргасан байх.
- Бараа, материалын тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй гэмтэл, элэгдэл хорогдлын зардлыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцана.
- Үйлдвэрлэгчийн гаргасан баталгаа худалдан авагчид байх ёстой. Баталгаат хугацаа хүлээн авсан өдрөөс эхлэн 12 сар үргэлжилнэ. Үйлдвэрлэгчээс олгосон урт хугацааны баталгааны хугацаа нь худалдан авагчид өөрчлөлтгүйгээр олгогдох ёстой.
- Бүрэн ажиллагааг хангахын тулд нийлүүлэгдэх бараа материалд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт тоноглол ба бүрэлдэхүүн хэсгүүд дагалдаж байх ёстой.

Дээрхи техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч буцаах, хүлээн авахгүй байх арга хэмжээ авах эрхтэй.

ХЯНАСАН:

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨХК-ИЙН
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР *П.Рэнцэндорж* П.РЭНЦЭНДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

“УЛААНГОМЫН ДУЛААНЫ ХОЁРДУГААР СТАНЦ” ТӨХК-ИЙН
ЗАСВАРЫН ИНЖЕНЕР *Г.Амартүшин* Г.АМАРТҮШИН